



Судлах тэмдэглэл

“Нягт нямбай хөтөлсөн мэдлэг бол хэрэгтэй цагт бэлэн байдаг мэдлэг юм. Сүнслэг нандин мэдээлэл нь таны үүнийг хэрхэн нандигнадгаа Их Эзэнд харуулж чадах тийм ариун нандин газарт хадгалагдах ёстой. Ингэж бичиж үлдээх нь таны гэрэл хүлээн авах цаашдын боломжийг нэмэгдүүлдэг.”

Ричард Г.Скотт, “Acquiring Spiritual Knowledge,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 88

АМЬД ХРИСТ

Төлөөлөгчдийн гэрчлэл

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

Есүс Христ хоёр мянган жилийн өмнө мэндэлснийг бид дурсан тэмдэглэхдээ Түүний зүйрлэшгүй амьдрал, агуу цагаатгагч золиослолын хэмжээлшгүй хүч нь үнэн бодитойг гэрчилдэг. Дэлхий дээр амьдарч байсан болон хойшид амьдрах бүх хүнд ийм хүчтэй нөлөөг өөр хэн ч үзүүлэхгүй юм.

Тэр бол Хуучин Гэрээний Агуу Иехова, Шинэ Гэрээний Мессиа билээ. Тэр бол Эцэгийнхээ удирдлаган дор дэлхийг бүтээсэн Бүтээгч. “Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юм нэг ч байхгүй” (Иохан 1:3). Тэрээр нүгэлгүй байсан ч аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэхийн тулд багтисм хүртэж ад үзэгдсэн ч “сайныг үйлдэж явлаа” (Үйлс 10:38). Түүний сайн мэдээ бол энх амгалан болон сайн санааны захиас байлаа. Тэрээр хүн бүхнийг Өөрийнхөө үлгэр жишээг дагахыг хүсч байлаа. Тэрбээр Палестины замуудаар алхан өвчтэйг эдгээж, хараагүйг хардаг болгон, үхэгсдийг босгож явлаа. Бас мөнхийн үнэнчүүд, мөнх бус байдлын өмнөх амьдралд бид оршин амьдарч байсан нь үнэн болохыг, дэлхий дээрх бидний амьдралын зорило, ирэх амьдрал дахь Бурханы хөвгүүд, охидын өсөн хөгжих боломжуудын тухай заадаг байв.

Тэрбээр ариун ёслолыг Өөрийн агуу цагаатгагч золиослолын сануулга болгон бий болгосон юм. Түүнийг баривчилж, хилс хэрэгт буруутган, хилэгнэсэн олны шаардлагыг биелүүлэхийн тулд Калварид загалмайд дуужлэн цаазаар авах ял оноосон билээ. Тэрээр бүх хүн төрөлхтний нүглийг цагаатгахын төлөө амиа өгсөн юм. Дэлхий дээр амьдарч байсан, амьдарч байгаа болон амьдарч бүх хүнд Түүний агуу бэлэг зориулагдсан юм.

Бүх хүн төрөлхтний түүхэнд гол суурийг эзэлдэг Түүний амьдрал Бетлехемд эхлээгүй бас Калвари дээр дуусаагүйг бид хүндэтгэлтэйгээр гэрчилж байна. Тэр бол Эцэгийн Ууган Хүү, махан биеэр төрсөн Эцэгийн Төрсөн Ганц Хүү, дэлхийн Гэтлэгч мөн.

Тэрээр булшнаас босч ирэн, “нойрсогсдоос анхны үр жимс болсон юм” (1 Коринт 15:20). Амилсан Их Эзэн мөнх бус үйлчлэлийнхээ үед хайрладаг байсан хүмүүс дээрээ очжээ. Тэр бас эртний Америк дахь “өөр хонин сүрэг” (Иохан 10:16)-тэй үйлчилсэн юм. Өнөөгийн дэлхийд Тэрбээр Эцэгийнхээ хамт Иосеф Смит хөвгүүн дээр хүрч ирэн, өнө эртнээс амлагдсан “цагийн дүүрнийг” (Ефес 1:10) эхлүүлсэн билээ.

Бошиглогч Иосеф Амьд Христийн тухай “Түүний мэлмий галын дөл лүгээ адил байв; тэргүүнийх нь үс цэвэрхэн цас мэт цав цагаан байв; түүний төрх байдал нарны гэрлээс ч илүү хурцаар гялалзаж байлаа; мөн дуу хоолой нь агуу их үс хуйлрах мэт байв, бүр Иеховагийн дуу хоолой өгүүлэн;

Бибээр эхнийх мөн эцсийнх болой; Бибээр амьдардаг тэрээр болой, би бол алагдсан тэрбээр бэлгээ; бибээр Эцэгийн өмнө та нарын өмгөөлөгч билээ” (С ба Г 110:3–4) хэмээн бичжээ.

Бошиглогч бас Түүний тухай “Мөн эдүгээ түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх хамгийн сүүлчийн гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө!

Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ.


Ийнхүү түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажтуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсөн хөвгүүд хийгээд охид нь бөлгөө” (С ба Г 76:22–24) гэж тунхагласан юм.

“Элч нар болон эш үзүүлэгчдийн . . . суурин дээр босгогдсон бөгөөд Есүс Христ Өөрөө булангийн чулуу нь болох” (Ефес 2:20) Түүний санваар, Түүний Сүм дэлхий дээр сэргээгдсэнийг бид хариуцлагатайгаар, хүндэтгэлтэйгээр тунхаглаж байна.

Тэрбээр нэгэн өдөр дэлхий дээр эргэж ирэх болно гэдгийг бид гэрчилж байна. “Дараа нь ЭЗЭНий алдар илэрхийлэгдэж, бүх махан бие хамтдаа үзнэ” (Исаиа 40:5). Тэрээр Хаадын Хаан, Эцэгийн Эзэн болж захиран хаанчлах бөгөөд Түүний өмнө өвдөг бүхэн сөрөхч мөн хэл бүхэн хүлээн зөвшөөрөн Түүнийг шүтэн бишрэх болно. Бид бүгд өөрсдийн үйлс, зүрх сэтгэлийнхээ хүслээр шүүгдэхийн учир Бурханы өмнө зогсох болно.



Бид зохих ёсоор томилогдсон Түүний Төлөөлөгчдийн хувьд Есүс бол Христ, Бурханы үхэшгүй Хүү гэдгийг гэрчилж байна. Тэр бол өнөөдөр Эцэгийнхээ баруун гар талд байгаа аугаа Иммануел Хаан мөн. Тэр бол дэлхийн гэрэл хийгээд амь амьдрал, итгэл найдвар болой. Түүний зам бол энэ дэлхийд аз жаргал хийгээд ирэх дэлхийд мөнх амьдрал өөд хөтөлдөг зам мөн. Юутай ч зүйрлэшгүй бэлэг болох тэнгэрлэг Хүүгийнх нь төлөө Бурханд талархал өргөө.

ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛ



2000 оны 1-р сарын 1

АРВАНХОЁРЫН ЧУУЛГА



Төгс эзэмших сургаалыг

судлах үндсэн материал

Төгс эзэмших сургаалын оршил

Мормоны Номд бошиглогч Хиламан: “Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун” (Хиламан 5:12) хэмээн хөвгүүддээ заасан байдаг. Есүс Христ дээр сууриа тавих гэдэгт Түүний сургаалыг ойлгон, итгэж, тэдгээрийн дагуу амьдрах явдал орох бөгөөд эдгээр нь илүү гүн хөрвөгдөн, шавийн хувьд хүлээсэн үүргийнхээ талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, дайсны нөлөөнөөс хамгаалан, бусдын амьдралыг адислахад бидэнд тусална.

Үүнийг хийж болох нэг арга зам бол судрыг ангиараа хамтран дэс дараатай судлах явдал юм. Есүс Христ, Түүний сургаал дээр сууриа тавих өөр нэгэн арга зам нь Төгс эзэмших сургаал хөтөлбөр юм.

Төгс эзэмших сургаалыг судалснаар дараах хоёр үр дүнд хүрнэ.

1. Сүнслэг мэдлэг олж авахад туслах тэнгэрлэг зарчмуудыг мэдэж авч, амьдралдаа хэрэгжүүлнэ.

Тэнгэрлэг Эцэг сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг илчилсэн. Эдгээр зарчимд итгэлээр үйлдэх, утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судлах, илүү гүн ойлголтыг тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан эрэлхийлэх зэрэг орно. Бид эдгээр зарчмыг амьдралдаа хэрэгжүүлж, сургаал ба түүхэн нөхцөл байдалтай холбоотой асуултыг Есүс Христ болон Түүний сургаалд итгэх итгэлийг

хүчирхэгжүүлдэг Ариун Сүнсийг урин авчрах арга замаар эрэлхийлбэл сургаалыг төгс эзэмших чадварыг хөгжүүлнэ.

2. Есүс Христийн сайн мэдээний сургаал болон сургаалыг зааж буй судрын хэсгийг төгс эзэмшинэ.

Төгс эзэмших сургаалын энэ үр дүнд дараах байдлаар хүрэх боломжтой.

а. Дараах сургаалын сэдвүүд болон сэдэв тус бүрд тодорхойлсон үндсэн мэдэгдлийн талаар илүү гүн гүнзгий ойлголтыг олж авах

- Бурхан Тэргүүтэн
- Авралын төлөвлөгөө
- Есүс Христийн Цагаатгал
- Сэргээлт
- Бошиглогчид ба илчлэлт
- Санваар ба санваарын түлхүүрүүд
- Ёслол ба гэрээнүүд
- Гэрлэлт ба гэр бүл
- Зарлигууд

б. Төгс эзэмших сургаалын судрын хэсэг дэх сургаалын мэдэгдэлд хэрхэн заадгийг мэдэж авах, тэдгээр хэсгийг санах, байгаа газрыг нь олж сурах

в. Сургаалын мэдэгдэл тус бүрийг холбогдох төгс эзэмших сургаалын судрын хэсгүүдийг ашиглан тодорхой тайлбарлах

г. Сурсан зүйлээ өдөр тутам сонголт хийхдээ мөн сургаал, нийгэм, түүхэн асуудал, асуултад хариулахдаа ашиглах

Сүнслэг мэдлэгийг олж авах нь

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд Өөртэй нь адил болж өсөж хөгжөөсэй гэж хүсдэг учраас биднийг “судлахаар мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийлэхэд” (С ба Г 88:118) урамшуулан дэмждэг. Бид үнэнийг эрэлхийлэхдээ бидэнд зааж, адислах Түүний мэргэн ухаан, хайр, хүч чадалд найдсанаар Түүнд бүрэн дүүрэн итгэж болно. Бурхан бүхнийг мэддэг бөгөөд бүх үнэнийг эхсурвалж мөн (Мозая 4:9-ийг үзнэ үү). Тэрээр үнэнийг бидний оюун санаа, зүрх сэтгэлд Ариун Сүнсээр дамжуулан илчилнэ хэмээн амласан байдаг (С ба Г 8:2–3-ыг үзнэ үү).

Тэнгэрлэг Эцэг бидэнд туслахын тулд сүнслэг мэдлэг хэрхэн олж авахыг заасан. Тэрээр уг мэдлэгийг олж авахын тулд дагах ёстой нөхцөлийг бидэнд өгсөн байдаг. Түүний бурханлаг загвар нь биднээс үнэнийг мэдэх гэсэн чин сэтгэлтэй байхыг (Моронай 10:4–5-ыг үзнэ үү), мөн Бурханы илчилсэн зүйлийн дагуу амьдрах хүсэлтэй байхыг шаарддаг (Иохан 7:17-г үзнэ үү). Чин сэтгэлийн хүсэл нь биднийг залбирлаар дамжуулан үнэнийг эрэлхийлэхэд (Иаков 1:5–6; 2 Нифай 32:8–9-ийг үзнэ үү), мөн Бурханы үгийг нухацтай судлахад хөтлөх болно. (2 Тимот 3:15–17; 2 Нифай 32:3-ыг үзнэ үү).

Зарим үед Сүмийн сургаал, зан үйл эсвэл түүхийн талаар ойлгоход бэрх шинэ мэдээлэл, асуулт гарч ирж болно. Асуулт тавьж, хариулт эрэлхийлэх нь үнэнийг мэдэж авахад гаргах бидний хүчин чармайлтын амин чухал хэсэг юм. Бидний оюун ухаанд орж ирдэг зарим асуулт Ариун Сүнсээр өдөөгдсөн байж болно. Сүнсээр өдөөгдсөн асуултыг бидний ойлголтыг өсгөн нэмэгдүүлдэг мөн Их Эзэн бидэнд заах хүсэлтэй гэсэн итгэлийг хүчирхэгжүүлэх боломжийг олгодог Бурханы бэлэг хэмээн үзэх нь зүйтэй. Асуулт нь ямар ч эх сурвалжаас гарсан бай, бид бодох, эргэцүүлэх, оюун ухааныг тэлэх, ойлголтыг маань гүнзгийрүүлэх Их Эзэний нөлөөллийг хүлээн авах чадвараар адислагдсан. Асуулт тавьж, хариулт эрэлхийлэхдээ харуулж буй хандлага, зорилго нь Ариун Сүнсээр дамжуулан суралцах бидний чадварт ихээхэн нөлөөлнө.

Итгэлээр үйлдэх, утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судлах, илүү гүн ойлголтыг тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан эрэлхийлэх гэсэн гурван зарчим нь бидэнд мөнхийн үнэнд суралцаж, ойлгохыг эрэлхийлж, асуулт болон асуудлыг шийдвэрлэхэд тусална.

1. Итгэлээр үйлд

Бид Бурханд итгэхийг сонгож, эхлээд Түүнд хандан чин сэтгэлээсээ дулбирч, сургаалаас суралцан, зарлигуудад нь дуулгавартай байснаар итгэлийнхнээ дагуу үйлддэг.

Бид ойлголтоо хөгжүүлж, асуудлыг шийдвэрлэхээр эрэлхийлж байхдаа Есүс Христ, Түүний сайн мэдээний сэргээлт болон томилогдсон бошиглогчдынх нь сургаалын талаар аль хэдийн бий болсон гэрчлэл дээрээ тулгуурлах нь зүйтэй. Ахлагч Жэффри Р.Холланд “Ийм зүйл тохиолдон, асуудал үүсч яаж шийдвэрлэгдэх нь тодорхой бус байх үед олж авсан итгэлээсээ зууран, илүү их мэдлэг олж автал тэвчээртэй байцаа” хэмээн заасан (“Эзэн минь, би итгэж байна,” *Ensign* эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 109). Их Эзэн биднийг “Санаа бодол болгондоо над уруу харатун; бүү эргэлз, бүү ай” (С ба Г 6:36) хэмээн урсан.

Тэр даруй асуултынхаа хариултыг олох боломжгүй үед Тэнгэрлэг Эцэг бидний авралд шаардагдах бүхнийг илчилсэн ч бүх үнэнийг хараахан илчлээгүй байгаа гэдгийг санаж байх нь тустай. Бид хариултыг үргэлжлүүлэн эрэлхийлэхдээ хэзээ нэгэн цагт хариултаа олно гэдэгтээ найдан, итгэлтэй амьдрах ёстой (Сургаалт үгс 3:5–6; Ифер 12:6-г үзнэ үү). Бид аль хэдийн хүлээн авсан үнэн болон гэрэлд итгэлтэй байх юм бол илүү их зүйлийг хүлээн авах болно. Асуулт, залбирлын хариулт ихэвчлэн “шат шатаар, дүрэм дүрмээр” (2 Нифай 28:30) өгөгддөг.

2. Утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал

Сургаалын утга санаа, асуулт, нийгмийн асуудлыг мөнхийн талаас нь шинжлэн судлахдаа бид

тэдгээрийг авралын төлөвлөгөө, Аврагчийн сургаалын хам сэдэвт нь авч үзэх хэрэгтэй. Бид аливаа зүйлийг Их Эзэний мэлмийгээр харахын тулд Ариун Сүнснээс тусламж эрэлхийлдэг. Энэ нь бидэнд дэлхийн таамаглал, ойлголтыг хүлээн авахын оронд асуултыг дахин боловсруулж (асуултыг өөр өнцгөөс харах), үзэл санааг Их Эзэний үнэний жишигт тулгуурлан (1 Коринт 2:5, 9-11-ийг үзнэ үү) харах боломжийг олгодог. Бид “Би Тэнгэрлэг Эцэг, Түүний төлөвлөгөө болон хүүхдүүдтэйгээ хэрхэн харилцдаг талаар юуг аль хэдийн мэдсэн байгаа вэ?” “Сайн мэдээний ямар сургаал энэ утга санаа, асуудалтай холбоотой эсвэл тэдгээрийг тодорхойлдог вэ?” гэх мэт асуултыг тавьж болно.

Түүхэн үйл явдалтай холбоотой асуултыг ч гэсэн мөнхийн талаас нь шинжлэн судлах хэрэгтэй байж болно. Бид Тэнгэрлэг Эцэг, Түүний авралын төлөвлөгөөнд итгэх итгэл дээр зангуугаа тавьсан хэвээр байж чадвал асуудлыг илүү тодорхой харах боломжтой. Түүнээс гадна түүхтэй холбоотой асуултыг орчин үеийн үзэл бодол, хандлагыг тулгалгүйгээр тухайн үеийн соёл, жишгийг харгалзаж үзэн, зохих түүхэн хүрээнд нь шинжлэн судлах нь тустай байж болно.

Түүхэн баримтууд нь ёслол, гэрээ, сургаалын аврах хүч чадлын талаар өгүүлдэггүй гэдгийг санах нь чухал. Сэргээлтийн гайхамшигийг нээж илрүүлэхийн оронд ач холбогдолгүй зүйлд анхаарлаа сарниулах нь хайрцган доторх гайхалтай бэлгийг үзэлгүйгээр зөвхөн хайрцгийг нь сонирхохтой адил юм.

3. Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү их ойлголт олж авахаар эрэлхийл

Их Эзэнээс тогтоосон сүнслэг мэдлэгийг олж авах үйл явцын нэг хэсэг болгон Тэрээр үнэн ба удирдамжийг Өөрийн хүүхдүүдэд илчлэх эх сурвалжийг бий болгосон. Эдгээр эх сурвалж нь Христийн гэрэл, Ариун Сүнс, судар, эх эцэг болон Сүмийн удирдагчид юм. Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Чуулга нь өнөө үеийн дэлхий дээрх Их Эзэний бошиглогчид бөгөөд үнэний амин чухал эх сурвалж мөн. Их Эзэн тэднийг Өөртэйгөө ярилцуулах зорилгоор сонгон, томилсон.

Түүнээс гадна бид үнэнийг бусад найдвартай эх сурвалжаас судлах боломжтой. Гэхдээ үнэнийг чин сэтгэлээсээ эрэлхийлэгчид найдваргүй эх сурвалжаас болгоомжлох хэрэгтэй. Бид олон хүн “Мууг сайн, сайныг муу гэж” (Исаиа 5:20) нэрлэж буй цаг үед амьдарч байна. Сатан нь худал хуурмагийн эцэг бөгөөд үнэнийг мушгин гуйвуулж, биднийг Их Эзэн, Түүний томилсон үйлчлэгчдээс нүүр буруулахад ятгахыг эрэлхийлдэг. Бид Их Эзэний тэнгэрээс томилогдсон эх сурвалж руу хариулт, удирдамж авахаар хандвал үнэн, бурууг ялган таних чадвараар адислагдана. Найдваргүй эх сурвалжийг таньж мэдэн, зайлсхийж сурах нь биднийг буруу ташаа мэдээллээс болон итгэлийг устгахыг эрэлхийлэгчдээс хамгаална.

Бусдад сүнслэг мэдлэг олж авахад нь туслах

Хүмүүс Сүмийн сургаал, зан үйл, түүхийн талаар асууж, сонирхон ирэх үед бид тэдний үнэнийг эрэлхийлж буй эрэл хайгуулд хэрхэн хамгийн сайнаараа тусалж болох вэ? Бид дараах арга замаар тэдэнд туслах боломжтой.

Анхааралтай бөгөөд залбирч сонс. Тэдний жинхэнэ асуултад хариулахын өмнө анхааралтай сонсож, тодруулж, ойлгохоор эрэлхийл. Асуултынх нь үнэн зорилго, мэдрэмж, итгэл үнэмшлийг ойлгохын тулд нухацтай эрж хай.

Сайн мэдээний үнэнийг зааж, гэрчил. Судрын болон орчин үеийн бошиглогчдын тохирох сургаалаас мөн уг сургаал таны амьдралыг хэрхэн өөрчилсөн талаар хуваалц. Ярьж байгаа хүндээ асуултаа сайн мэдээний болон авралын төлөвлөгөөний агуулгын хүрээнд шинжлэн судалж эсвэл өөрчлөн боловруулахад тусал.

Тэднийг итгэлийнхээ дагуу үйлдэхэд урь.

Их Эзэн биднээс сүнслэг мэдлэгийг өөрсдөө эрэлхийлэхийг шаарддаг гэдгийг сана. Тиймээс бид бусдыг залбирч, зарлигуудад дуулгавартай байж, Бурханы үгийг тууштай судалж, тэнгэрээс томилсон эх сурвалжийг, ялангуяа Мормоны Номыг ашиглах замаар итгэлээр үйлдэхэд урих ёстой. Шаардлагатай бол тэднийг нэмэлт мэдлэг олж авах хүртлээ Ариун Сүнс мэдэрч байсан үеийнхээ туршлагыг эргэн санаж, сурч мэдсэн үнэндээ үнэнч хэвээр үлдэхэд урамшуулан дэмж.

Эхэлсэн ажлаа дуусга. Хариулт хайж олно гэж амлан, дараа нь сурч мэдсэн зүйлээ хуваалцах замаар эхэлсэн ажлаа дуусга. Түүнээс гадна хариултыг хамтдаа хайж болно. Хувийн илчлэлт өгнө гэсэн Их Эзэний амлалтад итгэдэг гэдгээ илэрхийл.

Холбогдох эшлэлүүд: Иеремиа 1:4–5; Амос 3:7; Матай 5:14–16; Матай 16:15–19; Иохан 15:16; Иохан 17:3; Ефес 2:19–20; Ефес

4:11–14; 2 Нифай 2:27; Мозая 18:8–10; 3 Нифай 18:15, 20–21; С ба Г 1:37–38; С ба Г 18:15–16; С ба Г 21:4–6

Холбогдох сургаалын сэдвүүд: Бурхан Тэргүүтэн: Ариун Сүнс; Есүс Христийн Цагаатгал; Есүс Христэд итгэх итгэл; Бошиглогчид ба илчлэлт; Зарлигууд

Сургаалын сэдвүүд

1. Бурхан Тэргүүтэн

Бурхан Тэргүүтэн бол Бурхан Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ, Ариун Сүнс гэсэн тусдаа гурван хүн болно. Эцэг Хүү хоёр барьж мэдрэгдэх, өргөмжлөгдсөн яс, махан биетэй бол Ариун Сүнс нь сүнсэн хүн юм (С ба Г 130:22–23-ыг үзнэ үү). Тэд нэг зорилготой бөгөөд Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөг тохиолгон авчрахын төлөө төгс эв нэгдэлтэй ажилладаг.

Холбогдох шиллэлүүд: Эхлэл 1:26–27; Лук 24:36–39; Иосеф Смит—Түүх 1:15–20

Бурхан Эцэг

Бурхан Эцэг бол бидний шүтэн биширдэг Аугаа Нэгэн мөн. Тэр бол бидний сүнсний Эцэг (Еврей 12:9-ийг үзнэ үү). Тэрбээр төгс бөгөөд бүхнийг чаддаг мөн мэддэг. Түүнчлэн Тэрээр шударга, энэрэнгүй, нинжин сэтгэлтэй. Бурхан бүх хүүхдээ төгс хайрладаг бөгөөд бид Түүнтэй адил юм (2 Нифай 26:33-ыг үзнэ үү). Түүний ажил ба алдар суу нь үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах явдал билээ.

Холбогдох шиллэлүүд: Иохан 17:3; Мозая 4:9; Мосе 1:39

Есүс Христ

Есүс Христ бол сүнсээр төрсөн Эцэгийн Ууган Хүү, махан биеэр төрсөн Эцэгийн Төрсөн Ганц билээ. Эцэгийн удирдлага дор Есүс Христ тэнгэр болон газрыг бүтээсэн. Тэр бол Хуучин Гэрээний Иехова, Шинэ Гэрээний Мессиа мөн.

Есүс Христ бүх зүйлийг Эцэгийн тааллаар хийдэг. Тэр нүгэлгүй амьдралаар амьдарсан ба бүх хүн төрөлхтний нүглийг цагаатгасан (3 Нифай 11:10–11-ийг үзнэ үү). Түүний амьдрал бидэнд хэрхэн амьдрах ёстойг харуулсан төгс үлгэр жишээ мөн (3 Нифай 27:27-г үзнэ үү). Тэр бол Тэнгэрлэг Эцэгийн амилсан хүүхдүүдийн анхных нь байсан. Өнөө цагт, эрт дээр үеийн адил Тэрээр энэ Сүмийг тэргүүлдэг. Тэрээр хүч, алдар суундаа дахин ирж, Мянган жилийн турш дэлхий дээр хаанчлах болно (С ба Г 29:10–11-ийг үзнэ үү). Тэр бүх хүн төрөлхтнийг шүүнэ.

Есүс Христ бидний Аврагч, Эцэгт биднийг зүччиллэг учраас бүх залбирал, алислал ба

санваарын ёслол Түүний нэр дээр хийгдэх ёстой (3 Нифай 18:15, 20–21-ийг үзнэ үү).

Холбогдох шиллэлүүд: Исаиа 53:3–5; Лук 24:36–39; 1 Коринт 15:20–22; Илчлэлт 20:12; Алма 7:11–13; Алма 34:9–10; Хиламан 5:12; Моронай 7:45, 47–48; С ба Г 1:30; С ба Г 6:36; С ба Г 18:10–11; С ба Г 19:16–19; С ба Г 76:22–24

Холбогдох сэдэв: Есүс Христийн Цагаатгал

Ариун Сүнс

Ариун Сүнс бол Бурхан Тэргүүтэний гурав дахь гишүүн юм. Тэр сүнсэн хүн учраас биегүй. Түүнийг ихэвчлэн Сүнс, Ариун Сүнс, Бурханы Сүнс, Их Эзэний Сүнс эсвэл Тайтгаруулагч гэж нэрлэдэг.

Ариун Сүнс нь Эцэг Хүү хоёрыг гэрчилж, бүх зүйлийн үнэнийг илчлэн, нанамчилж, баптисм хүртсэн хүмүүсийг ариусгадаг. Бид Ариун Сүнсний хүчээр дамжуулан сүнсний адислалыг буюу бидний сайн сайхны төлөө мөн бусдад үйлчлэн, адислахад туслах адислал, чадварыг хүлээн авах боломжтой.

Холбогдох шиллэлүүд: Иохан 3:5; 1 Коринт 2:5, 9–11; 2 Нифай 32:3; 2 Нифай 32:8–9; Мозая 3:19; Мозая 18:8–10; 3 Нифай 27:20; Моронай 7:45, 47–48; Моронай 10:4–5; С ба Г 8:2–3; С ба Г 130:22–23

Холбогдох сэдвүүд: Сүнслэг мэдлэгийг олж авах нь; Ёслол ба гэрээний үгд

2. Авралын төлөвлөгөө

Мөнх бус оршихуйн өмнөх амьдралд Тэнгэрлэг Эцэг бидэнд Өөртэй нь адилхан болж, үхэшгүй байдал, мөнх амьдралыг олж авах боломжийг олгох нэгэн төлөвлөгөөг танилцуулсан юм (Мосе 1:39-ийг үзнэ үү). Бид төлөвлөгөөгөө биелүүлэн, Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болохын тулд Түүнийг болон Түүний Хүү Есүс Христийг таньж мэдэн, Тэдний зан байдал, шинж чанарын талаар зөв ойлголтой байх ёстой (Иохан 17:3-ыг үзнэ үү).

Судрууд Тэнгэрлэг Эцэгийн энэ төлөвлөгөөг “авралын төлөвлөгөө,” “аз жаргалын агуу төлөвлөгөө,” “нигүүлслийн төлөвлөгөө” гэж нэрлэдэг. Энэ төлөвлөгөөнд Бүтээлт, Уналт, Есүс Христийн Цагаатгал, сайн мэдээний бүх хууль, ёслол, сургаал багтдаг. Ёс суртахууны сонгох эрх буюу өөрсдөө сонгож, үйлдэх чадвар нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэн чухал хэсэг юм. Бидний мөнхийн өсөлт хөгжил энэ бэлгээ хэрхэн ашиглахаас шалтгаална (Иошуа 24:15; 2 Нифай 2:27-г үзнэ үү).

Есүс Христ нь Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний төвд байдаг. Авралын төлөвлөгөө нь бидэнд төгс төгөлдөр болж, бүрэн дүүрэн баяр баясгаланг хүлээн авч, гэр бүлийн харилцаа холбоогоо мөнхөд авч үлдэж, Бурхантай хамт мөнхөд амьдрах боломжийг олгодог.

Холбогдох эшлэлүүд: Малахи 4:5–6; 3 Нифай 12:48; С ба Г 131:1–4

Мөнх бус байдлын өмнөх амьдрал

Бид дэлхий дээр төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд Түүний сүнсэн хүүхдүүдийн хувиар амьдарч байсан билээ (Абрахам 3:22–23-ыг үзнэ үү). Энэхүү мөнх бус байдлын өмнөх оршихуйд бид Тэнгэрлэг Эцэгийн бусад хүүхэдтэй хамт тэнгэрт болсон зөвлөгөөнд оролцсон юм. Уг зөвлөгөөн дээр Тэнгэрлэг Эцэг Өөрийн төлөвлөгөөг танилцуулж, мөнх бус байдлын өмнөх амьдралд байсан Есүс Христ Аврагч болохоор гэрээ хийсэн билээ.

Бид сонгох эрхээ ашиглан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахаар болсон. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийг дагасан хүмүүст дэлхий дээр ирж, мөнх бус амьдралдаа туршлага хуримтлуулан, өсч хөгжин, улмаар мөнх амьдралд хүрэх боломжийг олгосон юм. Бурханы өөр нэгэн сүнсэн хүү Люсифер авралын төлөвлөгөөг эсэргүүцэн бослого гаргасан. Тэрээр Сатан болж, дагалдагчдынхаа хамт тэнгэрээс хөөгдсөнөөр бие махбодтой болж, мөнх бус байдалд туршлага олж авах боломжгүй болсон юм.

Холбогдох эшлэлүүд: Иеремиа 1:4–5; Еврей 12:9; 2 Нифай 2:27; 3 Нифай 11:10–11

Бүтээлт

Есүс Христ Эцэгийн удирдлаган дор тэнгэр ба газрыг бүтээсэн (С ба Г 76:22–24-ийг үзнэ үү). Дэлхийн бүтээлт Бурханы төлөвлөгөөнд зайлшгүй чухал байв. Дэлхий бол бие махбодтой болж, соригдон, бурханлаг зан төлөвийг хөгжүүлэх газар юм.

Адам бол дэлхий дээр бүтээгдсэн анхны хүн. Бурхан Адам, Ева хоёрыг Өөрийн дүр төрхөөр бүтээсэн. Бүх хүн төрөлтхөн—эрэгтэй мөн эмэгтэй—бүгд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн (Эхлэл 1:26–27-г үзнэ үү). Хүйс бол хувь хүн бүрийн мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнх амьдралын ялгах тэмдэг, зорилгынх нь онцлог шинж чанар юм.

Уналт

Едений цэцэрлэгт Бурхан Адам, Ева хоёрыг гэрлэлтээр холбосон. Адам, Ева хоёр цэцэрлэгт байхдаа Бурханы хажууд энэ хэвээр, мөнхөд амьдрах боломжтой байсан. Тэд цэвэр ариун байсан бөгөөд Бурхан тэдний хэрэгцээг хангаж байлаа.

Адам, Ева хоёрыг Едений цэцэрлэгт байхад нь Их Эзэн тэдэнд сонголт хийх боломжийг олгосон. Тэр тэдэнд сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс бүү ид хэмээн зарлигласан билээ. Түүний зарлигийг дагавал тэд цэцэрлэгт үлдэх байв. Гэхдээ Адам, Ева хоёр цэцэрлэгт үлдэх юм бол мөнх бус амьдрал дахь эсрэг тэсрэг байдлыг биеэрээ туулж, өсөж хөгжихгүй гэдгээ хараахан мэдэхгүй байлаа. Тэд үй гашуу, өвчин шаналлыг үзэхгүй учраас баяр баясгалан гэж юу болохыг ч мэдэх боломжгүй байв. Цаашилбал, тэд хүүхдүүдтэй болж чадахгүй байх байсан.

Сатан Адам, Ева хоёрыг хориглосон жимсийг ид хэмээн уруу татахад тэд идэх сонголтыг хийсэн. Энэ сонголтыг хийсэн учраас тэд Бурханы оршихуйгаас хөөгдөж, унасан бөгөөд мөнх бус болсон юм. Адам, Ева хоёрын зөрчил болон үүнээс үүдэлтэй өөрчлөлтүүд, түүний дотор сүнсний болон биеийн үхлийг Уналт хэмээн нэрлэдэг. Сүнсний үхэл нь Бурханаас тусгаарлагдахыг хэлнэ. Биеийн үхэл бол мөнх бус биеэс сүнс салах үйл явц мөн.

Уналт бол Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний амин чухал хэсэг юм. Уналтын үр дүнд Адам, Ева хоёр үр хүүхэдтэй болох боломжтой болсон. Уналтын үр дүнд тэд болон тэдний үр удам баяр баясгалан, үй гашууг биеэрээ туулж, муугаас сайныг ялган таньдаг болж, өсөж хөгжих боломжтой болсон юм (2 Нифай 2:22–25-ыг үзнэ үү). Бид Адам, Ева хоёрын үр удмын хувьд мөнх бус амьдралдаа Уналтын нөхцөл байдлыг өвлөн авсан. Бид Бурханаас тусгаарлагдан, биеийн үхэлд захирагддаг болсон. Түүнээс гадна бид мөнх бус амьдралын хүнд хэцүү зүйлс болон дайсны уруу таталтаар соригддог. Хэдийгээр бид Адам, Ева хоёрын зөрчлийн үр дагаврыг үүрэхгүй ч, өөрсдийн нүглийн үр дагаврыг хариуцах ёстой. Бид Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан Уналтын сөрөг үр дагаврыг ялан дийлж, нүглийнхээ өршөөлийг хүлээн авч, эцэст нь баяр баясгалангийн бүрэн байдлыг мэдрэх боломжтой.

Холбогдох эшлэлүүд: Эхлэл 1:28; Мозая 3:19; Алма 34:9–10

Холбогдох сэдэв: Есүс Христийн Цагаатгал

Мөнх бус амьдрал

Мөнх бус амьдрал нь сонгох эрхээ ашиглан Их Эзэний зарлигласан бүх зүйлийг хийнэ гэдгээ батлан, бурханлаг зан чанарыг хөгжүүлснээр өөрсдийгөө мөнх амьдралд бэлтгэн, суралцах хугацаа юм. Бид үүнийг Есүс Христ, Түүний Цагаатгалд итгэх итгэлээ хөгжүүлэн, наманчлал, баптисм, гишүүний баталгаа гэх мэт авралын ёслолыг хүлээн авч, гэрээ хийж, Есүс Христийн үлгэр жишээг мөнх бус амьдралынхаа эцсийн өдрийг хүртэл итгэлтэйгээр тууштай дагаснаар хийдэг.

Мөнх бус байдалд бидний сүнс бие махбодтой нэгдэн нийлж, бидэнд мөнх бус байдлын өмнөх дэлхийд боломжгүй байсан арга замаар өсч хөгжих боломжийг олгодог. Тэнгэр дэх Эцэг яс махан, бодит биетэй учраас бидэнд өсөж хөгжин, Түүнтэй адил болоход бие махбод хэрэгтэй. Бидний бие махбод ариун бөгөөд бид Тэнгэрлэг Эцэгийнхээ өгсөн энэ бэлэгт хүндэтгэлтэй хандах ёстой (1 Коринт 6:19–20-ийг үзнэ үү).

Холбогдох ишлэлүүд: Иошуа 24:15; Матай 22:36–39; Иохан 14:15; 2 Нифай 2:27; 3 Нифай 12:48; Моронай 7:45, 47–48; С ба Г 130:22–23

Холбогдох сэдвүүд: Бурхан Тэргүүтэн; Ариун Сүнс; Есүс Христийн Цагаатгал; Есүс Христэд итгэх итгэл; Ёслол ба гэрээнүүд; Зарлигууд

Үхлийн дараах амьдрал

Нас барсны дараа бидний сүнс сүнсний дэлхийд очиж, амилуулагдахыг хүлээнэ. Зөв шударга хүмүүсийн сүнсний диваажин хэмээн нэрлэгддэг аз жаргалын байдалд хүлээн авах юм. Үнэний талаар мэдлэггүй нас барсан мөн мөнх бус байдалдаа дуулгаваргүй байсан хүмүүс сүнсний дэлхийг гэгдэх мөнх бус байдлын дараах түр зуурын байдалд очно.

Эцэст нь хүн бүрд сайн мэдээний зарчмуудаас суралцан, ёслол ба гэрээнүүдийг хүлээн авах боломж олдох юм. Олон итгэлтэй хүн сүнсний шоронд байгаа хүмүүст номлоно. Сайн мэдээг хүлээн авч, наманчлал, тэдний өмнөөс ариун сүмд хийсэн авралын ёслолуудыг хүлээн авсан хүмүүс амилуулагдах хүртэл диваажинд амьдрах юм (1 Петр 4:6-г үзнэ үү).

Амилуулалт гэж бидний сүнс төгс төгөлдөр мах, ясан биетэйгээ дахин нэгдэхийг хэлнэ. Амилуулагдсаны дараа бид үхэшгүй мөнх болсон байх бөгөөд бидний сүнс ба бие махбод дахин хэзээ ч салахгүй. Есүс

Христ биеийн үхлийг ялан дийлсэн учраас дэлхий дээр төрсөн хүн бүр амилна (1 Коринт 15:20–22-ыг үзнэ үү). Зөв шударга хүмүүс ёс бусчуудаас өмнө амилж, анхны амилуулалтаар босч ирнэ.

Амилуулалтын дараа Эцсийн шүүлт болно. Есүс Христ хүлээн авах мөнхийн алдар сууг нь тодорхойлохын тулд хүн бүрийг шүүнэ. Энэхүү шүүлт нь хүн бүрийн хүсэл, Бурханы зарлигуудад хэр зэрэг дуулгавартай байсан зэрэгт үндэслэх юм (Илчлэлт 20:12–13-ыг үзнэ үү).

Судруудад алдар суугийн селестиел хаант улс, террестиел хаант улс, телестиел хаант улс гэсэн гурван хаант улсын талаар заадаг (1 Коринт 15:40–42-ыг үзнэ үү). Есүсийг гэрчлэхдээ зоригтой, сайн мэдээний зарчмуудад дуулгавартай байсан хүмүүс селестиел хаант улсад Бурхан Эцэг ба Түүний Хүү Есүс Христийн оршихуйд, гэр бүлийнхээ зөв шударга гишүүдтэй хамт амьдрах болно.

Холбогдох ишлэлүүд: Лук 24:36–39; Иохан 17:3; С ба Г 131:1–4

Холбогдох сэдвүүд: Есүс Христийн Цагаатгал; Ёслолууд ба гэрээнүүд

3. Есүс Христийн Цагаатгал

Мөнх бус байдлын өмнөх дэлхийд болсон зөвлөгөөнөөр Есүс Христ бидний Аврагч байхаар урьдчилан томилогдсон. Тэр бүх хүн төрөлхтнийг Уналтын сөрөг үр дагавраас гэтэлгэхээр мөн бидний гэм нүглийн төлөөсийг төлөхөөр Өөрийн хүслээр зовж шаналан, амиа өгсөн билээ. Есүс Христийн зовлон шаналал, үхэл, амилуулалтаар сүнслэг болон бие махбодын үхлийг ялан дийлсэн үйл явдлыг Цагаатгал хэмээн нэрлэдэг. Түүний золиослол бидний хүн нэг бүрд ач тустай бөгөөд Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд бүр зүйрлэхийн аргагүй үнэ цэнтэй гэдгийг харуулдаг (С ба Г 18:10–11-ийг үзнэ үү).

Есүс Христ бүх хүн төрөлхтний төлөө хэмжээлшгүй хийгээд мөнхийн золиослолыг хийж чадах цорын ганц хүн байсан учраас бид зөвхөн Түүгээр дамжуулан аврагдах боломжтой (Алма 34:9–10-ыг үзнэ үү). Зөвхөн Түүнд бие махбодын үхлийг ялан дийлэх хүч байсан. Тэрээр мөнх бус эх Мариагаасаа үхэх чадварыг өвлөн авсан. Харин Өөрийн мөнхийн Эцэг Бурханаас үүрд мөнхөд амьдрах буюу Өөрийн амийг өгч, дахин хүлээн авах хүчийг өвлөн авсан юм. Тэрээр ганцаараа биднийг гэм нүглээс гэтэлгэж чадах байв. Тэрээр төгс, нүгэлгүй

амьдралаар амьдарсан учраас шударга ёсны шаардлагаас чөлөөлөгдөж, нүглээ наманчилсан хүмүүсийн өрийг төлөх боломжтой байсан юм.

Түүний Цагаатгалд хүн төрөлхтний нүглийн төлөө Гетсеманий цэцэрлэгт үүрсэн зовлон шаналал, урсгасан цус, загалмай дээрх шаналал болон үхэл мөн булшнаас гарч ирсэн зэрэг нь багтдаг. Есүс бол амилсан анхны хүн байсан. Тэр булшнаасаа өргөмжлөгдсөн, мөнхийн мах, ясан биетэй боссон билээ (Лук 24:36–39-ийг үзнэ үү). Түүний Цагаатгалын ачаар бүх хүн төрөлхтөн төгс, мөнх бие махбодтой амилан, Бурханы оршихуйд шүүгдэхээр авчрагдах болно. Есүс Христийн гэтэлгэгч Цагаатгал нь Бурханы оршихуйд мөнхөд амьдрах боломжийг бидэнд олгохын тулд гэм нүглээсээ цэвэршин, өршөөгдөх цорын ганц арга замыг өгсөн юм (Исаиа 1:18; С ба Г 19:16–19-ийг үзнэ үү).

Есүс Христ Цагаатгалын нэгэн хэсгийн хувьд зөвхөн бидний нүглийн төлөө зовж шаналаад зогсохгүй, бүх хүн төрөлхтний өвчин шаналал, уруу таталт, өвчин эмгэг, сул дорой байдлыг Өөр дээрээ авсан (Исаиа 53:3–5; Алма 7:11–13-ыг үзнэ үү). Тэрээр өөрөө зовлон амссан учраас бидний зовлонг ойлгодог билээ. Бид Аврагчид итгэн, Түүнд ирвэл Тэр биднийг ачаагаа үүрэхэд мөн өөрсдийн хүчээр хийж чадахгүй зүйлсээ хийхэд хүчирхэгжүүлэх болно (Матай 11:28–30; Ифер 12:27-г үзнэ үү).

Есүс Христ бидний нүглийн төлөөсийг төлсөн нь хувийн үүрэг хариуцлагаас маань чөлөөлсөн гэсэн үг биш юм. Түүний золиослолыг хүлээн авч, нүглээсээ цэвэршин, мөнх амьдралыг өвлөн авахын тулд бид Түүнд итгэх итгэлээ хөгжүүлэн, наманчилж, баптисм хүртэж, Ариун Сүнснийг хүлээн авч, амьдралынхаа эцсийн өдрийг хүртэл тэвчих ёстой.

Холбогдох эшлэлүүд: Иохан 3:5; 1 Коринт 15:20–22; Мозая 3:19; 3 Нифай 11:10–11; 3 Нифай 27:20; С ба Г 76:22–24

Холбогдох сэдвүүд: Бурхан Тэргүүтэн; Есүс Христ; Авралын төлөвлөгөө; Уналт; Ёслол ба гэрээнүүд

Есүс Христэд итгэх итгэл

Сайн мэдээний анхны зарчим бол Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл мөн. Бидний итгэл Есүс Христ дээр төвлөрсөн цагт тэр биднийг аврал руу хөтөлнө (Хиламан 5:12-ыг үзнэ үү).

Есүс Христэд итгэх итгэлд Түүнийг Бурханы Төрсөн Ганц Хүү, дэлхийн Аврагч гэдэгт бат итгэх итгэл орно. Бид Түүний Хүүгийн хэмжээлшгүй Цагаатгалд итгэн, Есүс Христэд найдаж, Түүний сургаалыг дагах нь Тэнгэрлэг Эцэгтэйгээ эргэн амьдрах цорын ганц боломж гэдгийг мэднэ. Итгэл нь идэвхгүй сүсэг бишрэл биш бөгөөд Есүс Христэд итгэх жинхэнэ итгэл нь амьдралын маань хэв маягаар илэрдэг (Иаков 2:17–18-ыг үзнэ үү). Бид залбирч, судраас судалж, Бурханы зарлигуудад дуулгавартай байснаар итгэлээ хөгжүүлэх боломжтой.

Холбогдох эшлэлүүд: Сургаалт үгс 3:5–6; Ифер 12:6; С ба Г 6:36

Холбогдох сэдэв: Сүнслэг мэдлэгийг олж авах нь

Наманчлал

Есүс Христэд итгэх итгэл, Түүнийг болон Тэнгэрлэг Эцэгээ хайрлах бидний хайр нь наманчлал руу хөтөлдөг. Наманчлал нь сонголтынхоо үр дүнг үүрэх боломжтой бүх хүүхдэдээ зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэгэн хэсэг юм. Энэ бэлэг нь Есүс Христийн Цагаатгалууд боломжтой болсон. Наманчлал нь оюун ухаан, зүрх сэтгэлийн өөрчлөлт юм. Үүнд нүгэл үйлдэхгүй байх, бодол санаа, үйлдэл, хүслээ Бурханд хандуулан, өөрийн хүслийг Түүний хүсэлтэй нийцүүлэх зэрэг орно (Мозая 3:19-ийг үзнэ үү).

Наманчлалд нүглээ хүлээн зөвшөөрөх, нүгэл үйлдсэндээ бурханлаг харууслаар харуусах, Тэнгэрлэг Эцэгтээ мөн шаардлагатай бол бусдад нүгэл үйлдсэнээ хүлээх, нүглээ орхих, нүглийн улмаас учруулсан бүх хохирлыг аль болохоор бүрэн нөхөн төлөхийг хичээх, Бурханы зарлигуудад дуулгавартай амьдрах зэрэг багтдаг (С ба Г 58:42–43-ыг үзнэ үү). Их Эзэн баптисм хүртвэл бидний нүглийг өршөөнө хэмээн амладаг бөгөөд бид Аврагчийг дурсан санаж, Түүний зарлигуудыг дагах чин хүсэлтэйгээр ариун ёслолоос хүртэх бүрд уг гэрээгээ шинэчилдэг.

Бид чин сэтгэлийн наманчлал, Есүс Христийн Цагаатгалын ач ивээлээр дамжуулан Бурханы өршөөлийг хүлээн авч, амар амгаланг мэдрэх боломжтой. Бид Сүнсний нөлөөг илүү ихээр мэдэрч, Тэнгэрлэг Эцэгтэй болон Түүний Хүүтэй мөнхөд хамт амьдрахад улам бүр бэлтгэгдэх болно.

Холбогдох эшлэлүүд: Исаиа 1:18; Иохан 14:15; 3 Нифай 27:20; С ба Г 19:16–19

Холбогдох сэдэв: Ёслол ба гэрээнүүд

4. Сэргээлт

Бурхан Өөрийн үнэн, санваарын эрх мэдэл, Сүмийг дэлхийд дахин байгуулж, сайн мэдээг сэргээсэн. Эртний бошиглогчид хожмын үед тохиох сайн мэдээний сэргээлтийг зөгнөн хэлсэн байдаг (Исаиа 29:13–14; Үйлс 3:19–21-ийг үзнэ үү).

Сэргээлт нь 1820 оноос эхэлсэн. Бурхан Эцэг болон Түүний Хүү Есүс Христ Иосеф Смитийн залбирлын хариуд түүнд үзэгдсэн бөгөөд түүнийг Сэргээлтийн бошиглогчоор дуудсан (Иосеф Смит—Түүх 1:15–20-ийг үзнэ үү). Бурхан Иосеф Смитийг амьд Христийн хожмын үеийн гэрч болгохоор дуудсан билээ. Сэргээлтийн бошиглогчийн хувьд Иосеф Смит Мормоны Номыг Бурханы хүчээр орчуулсан юм (С ба Г 1:135:3-ыг үзнэ үү). Библи нь Мормоны Номтой хамт Есүс Христийг гэрчилдэг бөгөөд сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг (Езекиел 37:15–17-г үзнэ үү). Түүнчлэн Мормоны Ном нь Иосеф Смитийн бошиглолын дуудлага, Сэргээлтийн үнэнийг гэрчилдэг.

Сэргээлтийн нэгэн хэсэг болгон Бурхан Аароны болон Мелхизедек санваарыг сэргээлгэхээр тэнгэр элчүүдийг илгээсэн. Дараа нь Тэрээр 1830 оны 4-р сарын 6-нд Өөрийн Сүмийг шинээр зохион байгуулах удирдамжийг өгсөн. Бурхан Өөрөө Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг зохион байгуулсан тул энэ нь “бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм” (С ба Г 1:30) юм.

Холбогдох эшлэлүүд: Амос 3:7; Ефес 2:19–20; Ефес 4:11–14; С ба Г 13:1; С ба Г 76:22–24; С ба Г 107:8

Холбогдох сэдвүүд: Бурхан Тэргүүтэн; Бошиглогчид ба илчлэлт

Урвалт

Уналтын улмаас Бурханы үнэн, санваарын эрх мэдэл, Сүм нь хожмын үед сэргээгдэх хэрэгтэй болсон. Уналт нь нэг эсвэл түүнээс олон хүн сайн мэдээний үнэнээс нүүр буруулах үед тохиолддог.

Аврагч цовдлогдож, төлөөлөгчид нь нас барсны дараа олон хүн Аврагчийн тохируулсан үнэнээс татгалзсан (2 Тесалоник 2:1–3-ыг үзнэ үү). Хүмүүс сайн мэдээний зарчим, ариун судрын зарим хэсгийг гажуудуулан, үгүй хийсэн. Түүнчлэн Сүмийн зохион байгуулалт, санваарын ёслолуудыг зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн байна. Энэхүү өргөн цар хүрээтэй ёс бус зүйлийн

улмаас Их Эзэн санваарын эрх мэдлийг болон түлхүүрийг дэлхийгээс татан авсан юм. Хэдийгээр Бурханыг өөрт байгаа гэрлийн дагуу шүтэн биширч, залбирлынхаа хариултыг авдаг олон сайн, зөв шударга хүн байсан ч дэлхий ертөнц бошиглогчдоор дамжуулан өгөгддөг тэнгэрлэг илчлэлтгүй орхигдсон. Энэ цаг үеийг Их урвалт гэдэг.

Дэлхийн түүхэнд өөр олон урвалтын үе тохиолдсоор ирсэн.

Холбогдох сэдвүүд: Бошиглогчид ба илчлэлт; Санваар ба санваарын түлхүүрүүд; Ёслол ба гэрээнүүд

Эрин үе

Бурханы хүүхдүүд уналтын байдалд ороход Тэрээр бошиглогчдыг дуудан, бошиглогчдоороо дамжуулан сайн мэдээний адислалуудыг хүмүүст дахин шинээр өгөн, хайрлаж, тусламжийн гараа сунгасан. Их Эзэн Өөрийн үнэн, санваарын эрх мэдэл, ёслолуудыг илчилдэг цаг үеийг эрин үе гэдэг. Энэ бол Их Эзэн дэлхий дээр ариун санваартай, сайн мэдээг түгээх бурханлаг итгэмжлэл хүлээсэн, ёслолуудыг гүйцэтгэх дор хаяж нэг үйлчлэгч газар дэлхий дээр байх цаг үе юм.

Эрин үеүдийг Адам, Енох, Ноа, Абрахам, Моце, Есүс Христ болон бусад хүнээр тодорхойлдог. Их Эзэн бошиглогч Иосеф Смитээр дамжуулан эхлүүлсэн сайн мэдээний хожмын үеийн Сэргээлт нь эрин үеийн энэхүү загварын нэгэн хэсэг юм.

Эрин үе болгонд Их Эзэн болон Түүний бошиглогчид Сионыг байгуулахыг эрэлхийлдэг байсан. Сион гэдэг нь зүрх сэтгэлээрээ ариун, зөв шударга байдлаараа нэгдмэл, нэг нэгнээ халамжлан хайрладаг гэрээнд орсон хүмүүсийг хэлнэ (Моце 7:18-ыг үзнэ үү). Түүнчлэн Сион гэдэг нь цэвэр ариун зүрх сэтгэлтэй хүмүүс амьдардаг газрыг хэлнэ.

Өнөөдөр бид сүүлийн эрин үед буюу цаг хугацааны бүрэн байдалын үед амьдарч байна. Энэ нь урвалтаар төгсгөл болохгүй цорын ганц эрин үе юм. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм эцэст нь бүх дэлхийг бүрхэн, мөнхөд зогсох болно (Даниел 2:44-ийг үзнэ үү).

Холбогдох сэдвүүд: Бошиглогчид ба илчлэлт; Санваар ба санваарын түлхүүрүүд; Ёслол ба гэрээнүүд

5. Бошиглогчид ба илчлэлт

Бошиглогч бол Бурханыг төлөөлөн ярихын тулд Түүгээр дуудагдсан хүн юм (Иеремиа 1:4–5; Амос 3:7; Иохан 15:16; С ба Г 1:37–38-ыг үзнэ үү).

Бошиглогчид Есүс Христийн тухай гэрчилж, Түүний сайн мэдээг заадаг. Тэд Бурханы хүсэл, үнэн мөн чанарын тухай мэдүүлэн таниулдаг. Тэд нүглийг буруутган, үүний үр дагаврын талаар сэрэмжлүүлж, биднийг худал хуурмагаас зайлсхийхэд тусалдаг (Езекиел 3:16–17; Ефес 4:11–14-ийг үзнэ үү). Бошиглогчид заримдаа ирээдүйн үйл явдлыг бошиглодог. Бошиглогчид эрх мэдэл, илчлэлтээ Бурханаас хүлээн авдаг тул эдгээр үүрэг хариуцлагаа биелүүлдэг.

Илчлэлт нь Бурханы хүүхдүүдтэйгээ харилцах харилцаа юм. Ихэнх илчлэлт нь бодол, санаа, Ариун Сүнсний мэдрэмжээр дамжин ирдэг. Илчлэлт нь мөн үзэгдэл, зүүд, тэнгэр элчийн айлчлалаар ирдэг.

Их Эзэн мөнх бус тохинууллынхаа үеэр мөн бидний энэ үед бошиглогч, төлөөлөгч дээр үндэслэн Өөрийн Сүмийг дахин зохион байгуулсан юм (Ефес 2:19–20-ийг үзнэ үү). Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ерөнхийлөгч нь өнөө үед дэлхий дээр амьдарч байгаа бүх хүний Бурханы бошиглогч мөн. Бид Сүмийн ерөнхийлөгчийг бошиглогч, үзмэрч, илчлэгчийнх нь хувьд дэмжин баталдаг бөгөөд тэр бол Сүмийг бүхэлд нь удирдах илчлэлтийг хүлээж авдаг дэлхий дээрх цорын ганц хүн юм. Хэрэв бид Сүмийн бошиглогчийн сургаалыг итгэлтэй хүлээн авч, дуулгавартай дагавал Бурхан биднийг худал хуурмаг, хилэнцтийг ялан дийлэхэд тусалж адисална (С ба Г 21:4–6). Бид бас Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийг бошиглогч, үзмэрч, илчлэгч хэмээн дэмжин баталдаг билээ.

Ариун Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сууд хэмээх судрууд нь эртний болон хожмын үеийн бошиглогчдоор дамжуулан өгөгдсөн илчлэлтийг багтаадаг. Бошиглогчдын үгсийг судалснаар бид үнэнээс суралцаж, удирдамж хүлээн авдаг.

Хэдийгээр Бурхан Өөрийн бүх хүүхдийг удирдан залахын тулд бошиглогчдоор дамжуулан илчлэлт өгдөг ч хувь хүмүүс өөрийн онцгой хэрэгцээ, үүрэг

хариуцлага болон асуултад нь туслах, гэрчлэлээ хүчирхэгжүүлэх илчлэлтийг хүлээн авч чадна.

Гэхдээ Их Эзэнээс хүлээн авсан сүнслэг өдөөлт нь бошиглогчдоороо дамжуулан өгсөн илчлэлттэй хэзээ ч зөрдөггүй.

Холбогдох ишлэлүүд: Абрахам 3:22–23; Матай 16:15–19; 2 Тимот 3:15–17; 2 Нифай 32:3; С ба Г 8:2–3; С ба Г 76:22–24

Холбогдох сэдвүүд: Сүнслэг мэдлэгийг хүлээн авах нь; Санваар ба санваарын түлхүүрүүд

6. Санваар ба санваарын түлхүүрүүд

Санваар нь Бурханы мөнхийн эрх мэдэл ба хүч юм. Бурхан санваараар дамжуулан тэнгэр, газрыг бүтээсэн бөгөөд тэдгээрийг удирддаг билээ. Тэр энэ хүчээр дамжуулан Өөрийн хүүхдүүдийг гэтэлгэж мөн өргөмжилдөг.

Бурхан Өөрийнх нь нэрээр, хүүхдүүдийнх нь авралын төлөө үйлдэж мөн сэнхрүүлэхийн тулд санваарын эрх мэдлийг Сүмийн зохистой эрэгтэй гишүүдэд олгодог (С ба Г 121:36, 41–42-ыг үзнэ үү).

Санваарын түлхүүр нь ерөнхийлөгчийн зөвлөлийн эрх мэдэл буюу дэлхий дээр Бурханы хаант улсыг удирдан, чиглүүлэхийн тулд Бурханы хүмүүнд өгсөн хүч юм (Матай 16:15–19-ийг үзнэ үү). Санваарын түлхүүр нь сайн мэдээний номлолыг удирдан залж, авралын ёслолуудыг хийхэд шаардлагатай.

Есүс Христ Өөрийнхөө Сүмд хамааралтай санваарын бүх түлхүүрийг эзэмшдэг. Тэрээр төлөөлөгч бүрдээ дэлхий дээрх Бурханы хаант улсад хамаарах бүх түлхүүрийг олгосон юм. Сүмийн ерөнхийлөгч нь энэ бүх санваарын түлхүүрийг ашиглах зөвшөөрөлтэй цорын ганц хүн болно. Түүнчлэн ариун сүм, номлол, гадас, чуулгын ерөнхийлөгч болон бишоп бүр томилогдсон ажлаа тэргүүлэн, удирдах боломж олгодог санваарын түлхүүрүүдийг атгадаг.

Сүмд үйлчилдэг, эрэгтэй, эмэгтэй хүн бүр санваарын түлхүүрийг атгасан хэн нэгний удирдлаган дор дуудагддаг. Ингэснээр тэд үйлчлэхэд шаардагдах хүчийг хүлээн авч, дуудлагынхаа үүрэг хариуцлагыг биелүүлэх эрхтэй болдог (С ба Г 42:11-ийг үзнэ үү).

Аароны болон Мелкизедек санваарт томилогдсон хүмүүс санваарын тангараг ба гэрээнд ордог. Хэрэв тэд дуудлагаа хичээнгүйлэн хийж, Их Эзэн болон

Түүний үйлчлэгчдийг итгэлтэйгээр хүлээн авбал өргөмжлөлийн адислалыг хүлээн авна. Эмгэгтэйчүүд Их Эзэнтэй хийсэн гэрээндээ итгэлтэй байж чадвал өргөмжлөлийн амлагдсан адислалаас мөн адил хүртэж чадна.

Холбогдох ишлэлүүд: Иохан 15:16; Ефес 2:19–20

Холбогдох сэдвүүд: Сэргээлт; Бошиглогчид ба илчлэлт; Ёслол ба гэрээнүүд

Аароны санваар

Аароны санваарыг ихэвчлэн бэлтгэл санваар хэмээн нэрлэдэг. Аароны санваар нь “тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд наманчлалын сайн мэдээний мөн . . . баптисмын түлхүүрүүдийг атгадаг” (С ба Г 13:1). Энэ санваарыг ашиглан ариун ёслолыг бэлтгэн, адисалж, түгээдэг. Аароны санваарын албан тушаалууд нь дикон, багш, прист, бишоп юм.

Мелкизедек санваар

Мелкизедек санваар нь илүү дээгүүр эсвэл том санваар ба “ерөнхийлөн удирдах эрхийг атгадаг бөгөөд мөн дэлхийн бүх үед сүм дэх бүх албан тушаалд сүнсний зүйлүүдэд үйлчлэх хүч болон эрх мэдэлтэй байдаг” юм (С ба Г 107:8). Сүмийн бүх адислал, ёслол, гэрээ болон байгууллага нь Сүмийн буюу мелкизедек санваарын ерөнхийлөгчийн эрх мэдэл дор удирдагддаг. Энэхүү санваарыг Адамд өгсөн бөгөөд Их Эзэн Өөрийн сайн мэдээг илчлэх бүрд дэлхий дээр байсан билээ. Мелкизедек санваарын албанд ахлагч, дээд прист, патриарх, дал, төлөөлөгч орно.

Холбогдох ишлэл: Ефес 4:11–14

7. Ёслол ба гэрээнүүд

Ёслол

Ёслол гэж санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг ариун нандин зан үйлийг хэлнэ. Бурхан Сүнсний үнэнийг, ихэвчлэн бэлгэдлээр дамжуулан заах зорилгоор ёслол бүрийг бий болгосон байна.

Зарим ёслол нь өргөмжлөлд зайлшгүй чухал бөгөөд тэдгээрийг авралын ёслол хэмээн нэрлэдэг. Бид зөвхөн авралын ёслолыг хүлээн авч, холбогдох гэрээг сахиснаар Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан авах боломжтой болсон бүх адислалаас хүртэж чадна. Эдгээр авралын ёслолыг хүлээн авалгүйгээр бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан

болох эсвэл Түүний оршихуйд мөнх амьдрахаар эргэн очих боломжгүй (С ба Г 84:20–22-ыг үзнэ үү). Авралын ёслол нь санваарын түлхүүрийг атгадаг хүмүүсийн удирдлага дор хийгддэг.

Сайн мэдээний хамгийн анхны авралын ёслол нь эрх мэдэлтэй нэгнээр усанд умбуулан хүртэх баптисм юм. Баптисм нь хувь хүний хувьд Есүс Христийн Сүмийн гишүүн болж, селестиел хаант улсад ороход зайлшгүй хэрэгтэй чухал ёслол мөн (Иохан 3:5-ыг үзнэ үү).

Хувь хүн баптисм хүртсэний дараа нэг эсвэл түүнээс олон Мелкизедек санваартан толгой дээр нь гар тавьж түүнийг Сүмийн гишүүнээр баталж, Ариун Сүнсний бэлэг өгдөг (3 Нифай 27:20-ийг үзнэ үү). Ариун Сүнсний бэлэг нь Ариун Сүнсний нөлөөнөөс ялгаатай. Хүн баптисмаас өмнө Ариун Сүнсний нөлөөг мэдэрч, үнэний тухай гэрчлэлийг хүлээн авах боломжтой. Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсныхаа дараа гэрээгээ сахиж чадсан хувь хүн Ариун Сүнсний байнгын нөхөрлөлтэй байх эрхтэй болдог.

Авралын бусад ёслолд Мелкизедек санваарт томилох (эрэгтэйчүүд), ариун сүмийн хишиг хүртээх, гэрлэлтийг лацдан холбох зэрэг багтдаг. Түүнчлэн ариун сүмд эдгээр авралын ёслолыг нас барагсдын өмнөөс төлөөлөн хийж болно. Төлөөлөн хийх ёслолууд нь зөвхөн нас барсан хүн сүнсний дэлхийд тэдгээрийг хүлээн авч, холбогдох гэрээнүүдийг сахиснаар хүчин төгөлдөр болдог.

Өвчтөнийг адислах, хүүхдийг нэрлэх, адислах зэрэг бусад ёслол нь бидний сүнслэг өсөлт хөгжилд мөн адил чухал ач холбогдолтой.

Холбогдох ишлэлүүд: Малахи 4:5–6; Матай 16:15–19; 1 Петр 4:6; С ба Г 131:1–4

Холбогдох сэдвүүд: Бурхан Тэргүүтэн; Ариун Сүнс; Авралын төлөвлөгөө; Үхлийн дараах амьдрал; Есүс Христийн Цагаатгал; Санваар ба санваарын түлхүүрүүд

Гэрээнүүд

Гэрээ нь Бурхан, хүн хоёрын хоорондын ариун нандин тохиролцоо юм. Бурхан гэрээний нөхцөлийг тавьдаг бөгөөд бид Бурханы хийхийг хүсдэг зүйлсийг хийхээр зөвшөөрдөг. Бидний дуулгавартай байдлын хариуд Бурхан тодорхой адислал амладаг билээ (Египетээс гарсан нь 19:5–6; С ба Г 82:10-ыг үзнэ үү). Хэрэв бид гэрээгээ сахижгүй бол амлагдсан адислалыг хүлээн авахгүй.

Санваарын бүх авралын ёслолыг гэрээ дагалдан ирдэг. Жишээ нь, бид баптисм хүртэн Их Эзэнтэй гэрээнд ордог (Мозая 18:8–10-ыг үзнэ үү) бол Мелкизедек санваар авсан эрэгтэй хүн санваарын тангараг ба гэрээнд ордог. Бид ариун ёслолоос хүртсэнээр хийсэн гэрээгээ шинэчилдэг.

Бид ариун сүмд хишиг хүртэн, гэрлэлтийн лацдан холбох авралын ёслолыг хийлгэснээр дахин өөр гэрээнд ордог. Бид Их Эзэний тогтоосон зохистой байдлын жишгийн дагуу амьдарснаар өөрийн биенийг ариун сүмийн ёслолд оролцон, гэрээнд ороход бэлддэг (Дуулал 24:3–4-ийг үзнэ үү). Ариун сүм нь үнэхээр Их Эзэний өргөө тул бид ариун сүмд орохуйц зохистой байх нь нэн чухал билээ. Энэ нь дэлхий дээрх шүтэж бишрэх хамгийн ариун газар юм.

8. Гэрлэлт ба гэр бүл

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гэрлэлт Бурханаас заяагддаг бөгөөд гэр бүл нь Түүний авралын ба аз жаргалын төлөвлөгөөний төвд байдаг (Эхлэл 2:24; С ба Г 49:15–17-г үзнэ үү). Зөвхөн селестиел гэрлэлтийн гэрээнд орж, гэрээгээ тууштай сахиснаар эрэгтэй, эмэгтэй хүн өөрсдийн бурханлаг хийгээд мөнхийн чадавхаа гүйцэлдүүлж чадна (1 Коринт 11:11; С ба Г 131:1–4-ийг үзнэ үү).

Бурхан хүүхдүүдээ өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэж хэмээн зарлигласан байдаг (Эхлэл 1:28-ийг үзнэ үү). Үр удмаа үлдээх ариун нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэж, эхнэр нөхөр болсон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой. (Эхлэл 39:9; Алма 39:9-ийг үзнэ үү). Эхнэр нөхөр хоёр нь бие биеэ болон үр хүүхдээ хайрлан халамжлах хариуцлага хүлээнэ. Эцэг эхчүүд нь үр хүүхдээ хайрлан халамжилж, зөв шударгаар өсгөн хүмүүжүүлэх, бие бялдар, оюун санааных нь хэрэгцээг хангах үүрэгтэй.

Гэр бүлийн амьдрал Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн байвал аз жаргалтай байх нь гарцаагүй. Эцэг хүн тэнгэрлэг загварын дагуу өрх гэрээ энэрэл хайр, зөв шударгаар тэргүүлэн, ахуй амьдралын хэрэгцээг зүйлсээр хангах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой.

Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөөний дагуу гэр бүлийн харилцаа холбоогоо насан эцэслэснийхээ дараа ч гэсэн үргэлжлүүлэх боломжтой. Гэр бүлийг бий болгон, лацдан холбож, үүрд мөнхөд өргөмжлөхийн тулд дэлхий бүтээгдэж, сайн мэдээ илчлэгдсэн юм. Бид гэр бүлийн түүх, ариун сүмийн ёслолоор дамжуулан сайн мэдээний ёслол, гэрээнүүдийг өвөг дээдсийнхээ өмнөөс хийх боломжтой (Малахи 4:5–6-г үзнэ үү).

(Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign*, 2010 оны 11-р сарын эсвэл 2010 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 129-өөс тохируулан авав.)

Холбогдох шилэүүд: Мосе 1:39; Эхлэл 1:26–27; Египетээ гарсан нь 20:3–17; Матай 16:15–19; Иохан 17:3; 1 Коринт 6:19–20; 2 Нифай 2:22–25; Мозая 2:41; Алма 41:10; С ба Г 84:20–22

Холбогдох сэдвүүд: Авралын төлөвлөгөө; Зарлигууд

9. Зарлигууд

Зарлигууд гэдэг нь бидэнд өсөж хөгжин, Бурхантай адил болоход тусалдаг Түүнээс бидэнд өгсөн хууль, шаардлагыг хэлнэ. Зарлигууд нь Бурханы биднийг хайрлах хайрын илрэл юм. Бид зарлигуудыг дагаснаараа Бурханыг хэрхэн хайрладагаа харуулдаг (Иохан 14:15-ыг үзнэ үү). Зарлигийг дагах нь үргэлж аз жаргал, Их Эзэний адислагыг авчирдаг (Мозая 2:41; Алма 41:10-ыг үзнэ үү). Их Эзэн хэзээ ч бидэнд Өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг зэхэлгүйгээр зарлигийг өгдөггүй (1 Нифай 3:7).

Хамгийн чухал хоёр зарлиг бол “бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла. . . . Мөн . . . хөршөө өөрийн адил хайрла” юм (Матай 22:36–39-ийг үзнэ үү). Бид бусдыг хайрлан, тэдэнд үйлчлэх сонголтыг хийснээр Бурханыг хайрлан, Түүнд үйлчилдэг (Мозая 2:17; Моронай 7:45, 47–48-ыг үзнэ үү).

Хүмүүнд хамгийн түрүүнд өгсөн зарлигуудын нэг бол Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахиу юм. Бурхан хүүхдүүдээ Хүндэтгэлийн өдрөөр өөрсдийн бус Өөрийнх нь хүслээр үйлдсэнээр Өөрийг нь дээдлэхийг зарлигласан (Исаиа 58:13–14).

Арван зарлиг бол сайн мэдээний чухал хэсэг бөгөөд бидний өргөмжлөлд шаардлагатай мөнхийн зарчмууд болно (Египетээс гарсан нь 20:3–17-г үзнэ үү). Их Эзэн эрт дээр үед эдгээр зарлигийг Мосед илчилсэн бөгөөд хожмын үеийн илчлэлтээр дахин өгсөн байдаг.

Бурханы зарлигт өдөр бүр залбирах, Бурханы үгийг судлах, наманчлах, ариун явдлын хуулийг сахих, аравны нэгийг бүрэн төлөх (Малахи 3:8–10), мацаг барих (Исаиа 58:6–7), бусдыг уучлах (С ба Г 64:9–11-ийг үзнэ үү), мэргэн ухааны хуулийг дагах (С ба Г 89:18–21-ийг үзнэ үү), мөн бусдад сайн мэдээг заах (Матай 5:14–16; С ба Г 18:15–16-г үзнэ үү) зэрэг ордог.

Холбогдох зиллэлүүд: Эхлэл 39:9; 2 Тимот 3:15–17; Иаков 1:5–6; 2 Нифай 32:3; 2 Нифай 32:8–9; Мозай 18:8–10; Алма 39:9; 3 Нифай 18:15, 20–21; С ба Г 58:42–43; С ба Г 82:10

Холбогдох сэдвүүд: Сүнслэг мэдлэгийг олж авах нь; Есүс Христий Цагаатгал; Наманчлал; Еслол ба гэрээнүүд

Эдгээр сэдвийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг [lds.org](https://www.lds.org) руу орж, Gospel Library, Gospel Topics; эсвэл *Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт*-аас үзнэ үү (2004).

Төгс эзэмших сургаалын хэсгүүд

Төгс эзэмших 100 судрын жагсаалтыг харуулав.

Хуучин Гэрээ	Шинэ Гэрээ	Мормоны Ном	Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүх
Моше 1:39	Матай 5:14–16	1 Нифай 3:7	ИС—Т 1:15–20
Моше 7:18	Матай 11:28–30	2 Нифай 2:22–25	С ба Г 1:30
Абрахам 3:22–23	Матай 16:15–19	2 Нифай 2:27	С ба Г 1:37–38
Эхлэл 1:26–27	Матай 22:36–39	2 Нифай 26:33	С ба Г 6:36
Эхлэл 1:28	Лук 24:36–39	2 Нифай 28:30	С ба Г 8:2–3
Эхлэл 2:24	Иохан 3:5	2 Нифай 32:3	С ба Г 13:1
Эхлэл 39:9	Иохан 7:17	2 Нифай 32:8–9	С ба Г 18:10–11
Египетээс гарсан нь 19:5–6	Иохан 14:15	Мозая 2:17	С ба Г 18:15–16
Египетээс гарсан нь 20:3–17	Иохан 15:16	Мозая 2:41	С ба Г 19:16–19
Иошуа 24:15	Иохан 17:3	Мозая 3:19	С ба Г 21:4–6
Дуулал 24:3–4	Үйлс 3:19–21	Мозая 4:9	С ба Г 29:10–11
Сургаалт үгс 3:5–6	1 Коринт 2:5, 9–11	Мозая 18:8–10	С ба Г 42:11
Исаиа 1:18	1 Коринт 6:19–20	Алма 7:11–13	С ба Г 49:15–17
Исаиа 5:20	1 Коринт 11:11	Алма 34:9–10	С ба Г 58:42–43
Исаиа 29:13–14	1 Коринт 15:20–22	Алма 39:9	С ба Г 64:9–11
Исаиа 53:3–5	1 Коринт 15:40–42	Алма 41:10	С ба Г 76:22–24
Исаиа 58:6–7	Ефес 2:19–20	Хиламан 5:12	С ба Г 82:10
Исаиа 58:13–14	Ефес 4:11–14	3 Нифай 11:10–11	С ба Г 84:20–22
Иеремиа 1: 4–5	2 Тесалоник 2:1–3	3 Нифай 12:48	С ба Г 88:118
Езекиел 3:16–17	2 Тимот 3:15–17	3 Нифай 18:15, 20–21	С ба Г 89:18–21
Езекиел 37:15–17	Еврей 12:9	3 Нифай 27:20	С ба Г 107:8
Даниел 2:44	Иаков 1:5–6	Ифер 12:6	С ба Г 121:36, 41–42
Амос 3:7	Иаков 2:17–18	Ифер 12:27	С ба Г 130:22–23
Малахи 3:8–10	1 Петр 4:6	Моронай 7:45, 47–48	С ба Г 131:1–4
Малахи 4:5–6	Илчлэлт 20:12	Моронай 10:4–5	С ба Г 135:3


Өдөр тутам уншсан судраа тэмдэглэх хүснэгт

1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
3	3	3	3	3	3	3	3	3	3	3	3
4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4
5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
6	6	6	6	6	6	6	6	6	6	6	6
7	7	7	7	7	7	7	7	7	7	7	7
8	8	8	8	8	8	8	8	8	8	8	8
9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9
10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10
11	11	11	11	11	11	11	11	11	11	11	11
12	12	12	12	12	12	12	12	12	12	12	12
13	13	13	13	13	13	13	13	13	13	13	13
14	14	14	14	14	14	14	14	14	14	14	14
15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15
16	16	16	16	16	16	16	16	16	16	16	16
17	17	17	17	17	17	17	17	17	17	17	17
18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18
19	19	19	19	19	19	19	19	19	19	19	19
20	20	20	20	20	20	20	20	20	20	20	20
21	21	21	21	21	21	21	21	21	21	21	21
22	22	22	22	22	22	22	22	22	22	22	22
23	23	23	23	23	23	23	23	23	23	23	23
24	24	24	24	24	24	24	24	24	24	24	24
25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25
26	26	26	26	26	26	26	26	26	26	26	26
27	27	27	27	27	27	27	27	27	27	27	27
28	28	28	28	28	28	28	28	28	28	28	28
29	(29)	29	29	29	29	29	29	29	29	29	29
30		30	30	30	30	30	30	30	30	30	30
31		31		31		31	31		31		31












































































































ГЭР БҮЛ

ДЭЛХИЙ ДАХИНАА ӨРГӨХ ТУНХАГ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл

Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн тэргүүн зөвлөл ба арванхоёр төлөөлөгчийн зөвлөлийнхөн бид эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь Бурханаас заяасан бөгөөд гэр бүл нь Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна.

Бүх хүн төгөлдөг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг Бурхан, өө-

юм” (Дуулал 127:3). Эцэг эхчүүд нь хүүхдүүдээ хайр, зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биеэ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидгаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Эхнэр нөхөр, эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

All content on this page has
been previously approved.
No changes will be
permitted on this page

дүүргэ” хэмээсэн зарлиг нь хүчин төгөлдөр байгааг тунхаглаж байна. Түүнчлэн “Үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой” хэмээсэн Бурханы зарлигийг тунхаглаж байна.

Мөнх бус амьдралын арга зам нь тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал, түүний ач холбогдлын чухлыг бид батлан хэлж байна.

Эхнэр нөхөр хоёр нь бие биеэ болон үр хүүхдээ хайрлан халамжлах хариуцлага хүлээнэ. “Үр хүүхэд бол Их Эзэний өв

Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэх болохыг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах арга замуудыг ямагт хэрэгжүүлэгч хэмээн уриалан дуудаж байна.

Энэхүү тунхгийг 1995 оны 9 сарын 23-нд Юта мужийн Солт Лейк хотноо болсон Ерөнхий Нийгмийн Халамжийн бүлгийн чуулган дээр Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли захиасныхаа нэгэн хэсэг болгон уншсан юм.

Шашны институт, семинарын зорилго

Бидний зорилго бол өсвөр үеийнхэн ба залуучуудад Есүс Христийн сургаал, Цагаатгалыг ойлгон, тэдгээрт найдаж, ариун сүмийн адислалыг хүртэхүйц зохистой байж, өөрсдийгөө болон гэр бүлээ мөн бусдыг Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрах мөнх амьдралд бэлтгэхэд туслах явдал юм.

Эдгээр зорилгод хүрэхийн тулд институт, семинарын багш болон суралцагчдыг сайн мэдээг заах, судлах үндсийг амьдралдаа хэрэгжүүлэхэд дэмжих ёстой.

Багш, суралцагчид:

- Сүнсээр заах, суралцах;
- Хайр, хүндэтгэл, зорилго бүхий суралцах орчинг бүрдүүлэх;
- Судраас өдөр бүр судалж, хичээлийн материалыг унших;
- Судрууд болон бошиглогчдын үгсийн хам сэдэв, агуулгыг ойлгох;
- Сайн мэдээний сургаал, зарчмуудын үнэн ба ач холбогдлыг олж тогтоон, ойлгож, мэдрэх мөн тэднийг амьдралдаа хэрэгжүүлэх;
- Сайн мэдээний сургаал, зарчмуудыг тайлбарлан, хуваалцаж, гэрчлэх;
- Төгс эзэмших сургаалыг эзэмших хэрэгтэй.



ШАШНЫ ИНСТИТУТ БА СЕМИНАР

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

